



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БОР-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 06 сарын 11 өдөр

Дугаар A/185

Бор-Өндөр сум


Газар ашиглалтын зориулалт өөрчлөх

тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 66.3 дахь хэсэг, Газар зохион байгуулалт, геодези зурагзүйн газрын даргын 2021 оны A/187 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Газар эзэмших, ашиглах гэрчилгээ олгох журам"-ын 8.10 дахь хэсэг, Хэнтий аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бор-Өндөр сумын 5 дугаар багийн нутаг дэвсгэрт байрлах иргэний эзэмшлийн газрын зориулалтыг эзэмшигч иргэний хүсэлтийг харгалзан, аймгийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсанаар, нэгдүгээр хавсралтад заасны дагуу өөрчлөн эзэмшүүлсүгэй.
2. Газар ашиглалтын зориулалт өөрчлөгдсөн газрын мэдээллийг захирамжийн дагуу Газрын кадастрын мэдээллийн санд тусгахыг Газрын даамал /Т.Эрдэнэзаяа/-д зөвшөөрсүгэй.
3. Газар эзэмшүүлэх гэрээнд заасан зориулалт, нөхцлийн дагуу газраа эзэмшин, гэрээг жил бүр дүгнүүлж ажиллахыг газар эзэмшигч иргэнд үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.АДЪЯАБИЛЭГТ



 Сумын Засаг даргын 2024 оны

 06 дугаар сарын 11-ны өдрийн

 А/105 дугаар захирамжийн 1-р хавсралт

Газар эзэмшигч болон газрын мэдээлэл

Газар эзэмшигчийн			Газрын			
д/д	Хуулийн этгээдийн нэр	Регистр	Хэмжээ	Нэгж талбарын дугаар	Шинэчилсэн зориулалт	Эзэмших хугацаа /жил/
			/м ² /			
1	Боржигин Шагдаржав Бямбасүрэн	СЦ71060118	20000.0	2322002601	2602: Уул уурхайн үйлдвэрлэлийн барилга, байгууламж	10
						5-р баг, Үйлдвэр-1 гудамж, 117 тоот